

СУРАГЧДААС БАГШИЙН ДҮР ТӨРХ, ГОО ЗҮЙД ХАНДАХ БАЙДЛЫГ СУДАЛСАН НЬ

*Д. Ариунтогос
Магистр*

*Шинжлэх ухаан, технологийн их сургууль
Бизнесийн удирдлага, хүмүүнлэгийн сургууль*

ariuntogosd@gmail.com

*Д. Алтанзул
Магистр*

*Өвөр Монголын багшийн их сургууль
Сэтгэл судлалын сургууль*

azul_d2002@yahoo.com

Хураангуй: Олонхи хүмүүс багшийнхаа дүр төрх, гоо зүйн талаар өөртөө тодорхой бодлыг агуулж байдаг. Багшийн дүр төрх, гоо зүйн талаарх та бидний бодол санаа энгийн асуудал юм шиг атлаа багш мэргэжилд олон нийтээс өгч буй үнэлэмж бөгөөд энэ нь нөгөө талаас боловсрол судлал, сэтгэл судлал, имиж судлал, этик, эститикийн судлагдахуун юм. Ахлах ангийн сурагчид бие бялдар, сэтгэл зүйн хувьд бие хүн болон төлөвшихдөө өөрийн хамгийн ойр дотны харилцагч, үлгэр дууриал авдаг хүн болох багшийн талаар өөр өөр санаа бодолтой байдаг хэдий ч багш хүний дүр төрхийг сэтгэхүйдээ бүтээж түүний гоо сайханд үнэлгээ өгч энэ нь тэдний зан чанар, гоо зүйн хөгжилд урт гүнзгий нөлөө үзүүлж байдаг. Хэдийгээр шилдэг багш бүр өөр өөрийн дүр төрхтэй байдаг энэ нөхцөл байдлын талаар ЕБС-ийн сурагчдаас багшийн дүр төрх, гоо зүйд хандах байдлыг судалж, багшийн шилдэг “хэв маяг”-ийг тодорхойлоход тухайн эрдэм шинжилгээний өгүүллийн зорилго оршино.

Түлхүүр үг: Монгол үндэстэн, сурагчид, багш нар

УДИРТГАЛ

1990-ээд оноос хойш олон орны эрдэмтэн судлаачид "багшийн дүр төрх"-ийг эрдэм шинжилгээний асуудал, ойлголт болгон аажмаар судалж эхэлсэн боловч эрдэм шинжилгээний хүрээлэлд "багшийн дүр төрх" гэсэн тодорхойлолтын нэр хүндтэй тодорхойлолт байдаггүй бөгөөд янз бүрийн судалгаанууд байдаг. "Багшийн дүр төрх" гэсэн ойлголт нь "имидж", "нийгмийн дүр төрх" эсвэл "мэргэжлийн дүр төрх" гэсэн ойлголтоос гаралтай. Судалгааны өөр өөр өнцөг, хэмжигдэхүүнээс шалтгаалан багшийн дүр төрхийг судлах судалгааны ажлын агуулга, бүтцийн талаар эрдэмтэд өөр үзэл бодолтой байдаг [1]. Багшийн сурагчидтай шууд харьцах явцад багшийн дүр төрхийг мэдэх нь сурагчдын сэтгэл зүйн мэдээллээс багшийн хэл ярианы мэдээлэл, биеийн байрлалын мэдээлэл, сэтгэл зүйн

янз бүрийн мэдээлэлд үзүүлэх сэтгэл хөдлөлийн цогц хариу үйлдэл юм гэж Чю Гуанчай үзжээ. Багшийн дүр төрхийг бий болгох нь багш, сурагчдын харилцан үйлчлэлийн үр дүн бөгөөд энэ нь сурагчдын багшийн талаарх ойлголт, хандлагаас ихээхэн хамаардаг [2].

ОНОЛ, АРГА ЗҮЙН ХЭСЭГ

Гоо сайхны таашаал нь (Aesthetic Preference) философи, сэтгэл судлалын салбарын үндсэн ойлголтуудын нэг бөгөөд хувь хүний гоо зүйн сэтгэл зүйн бүтцийн чухал хэсэг болохын хувьд үнэлэмж асуудал давамгайлж байдаг. Эртний Грекчүүд гоо зүйн гарал үүслийн талаар олон таамаглал дэвшүүлсэн байдаг [3]. Энэ үеэс ХХ зууны эхэн үе хүртэл “дуураймал онол”, “биологийн зөн совингийн онол”, “тоглоомын онол” зэрэгт гоо зүйн таашаалын талаар харьцангуй нөлөөлж ирсэн [4].

Грекийн сэтгэгч Демокрит, Аристотель нар дуураймал онолыг анх дэвшүүлэхдээ бүх урлаг нь байгаль, нийгмийн үзэгдлийг дуурайхаас үүдэлтэй гэж үздэг. Хүний гоо зүйн асуудлыг энгийнээр тайлбарлах нь объектив бодит байдлаас үүдэлтэй. Гэвч энэ онол нь аливаа зүйлийн өнгөн талыг л хөндөж, мөн чанарыг нээж, гоо зүйн үндсэн шалтгаанудыг тайлбарлаж чадахгүй байв. Гэвч дуураймал орчин, дуураймал объект, дуураймал аргуудын хувьд хүний ялгаа нь гоо зүйн давуу талыг бий болгоход хүргэдэг [5]. “Дуураймал” гэдэг нь хүний мөн чанар, зөн совин бөгөөд хүн амьтдын хамгийн том ялгаа нь хүн төрөлхтөн “дууриах” чадварт сайн байдаг бөгөөд энэ нь тодорхой хэмжээний ухамсартай болдогт оршино. Хүн бүр үүнээс таашаал авдаг ч энэ нь хүн бүрт өөр өөр байдаг бөгөөд энэхүү хувийн “дууриамал” ялгаа нь гоо зүйн ялгаатай байдалд хүргэдэг [6]. XIX зуунаас эхлэн барууны орнуудад гоо зүйн онолын судалгаа, антропологи тасралтгүй хөгжихийн хэрээр гоо зүйн үзэмжийн шинэ үзэл баримтлалыг бий болгожээ. Английн антропологич Эдвард Тейлор “Анхны соёл” бүтээлдээ гоо үзэсгэлэн нь “ид шид”-ээс үүсэлтэй [7] гэдгийг онцлоод эртний хүмүүсийн сэтгэхүй орчин үеийн хүмүүсийн сэтгэхүйгээс өөр. Балар эртний үеийн хүмүүсийн хувьд тэдний эргэн тойронд байгаа орчин нь маш нууцлаг бөгөөд энэ нь тэднийг гайхшруулдаг. Хүмүүсийн сэтгэлгээ нь голчлон анимизм бөгөөд хүрээлэн буй орчны ургамал, мод нь хүмүүст урам зориг өгдөг. Энэ ухамсар нь гоо зүйг бий болгодог гэж үзсэн байдаг.

“Биологийн зөн совингийн онол”-ын төлөөлөгчид нь Ч.Дарвин, З.Фрейд нар хүний гоо зүй нь эсрэг хүйстэн хүмүүсийг өөртөө татах зөн совингоос үүсэлтэй бөгөөд гоо зүйн болон урлагийн бүхий л бүтээлүүд бэлгийн зөн совингоос эхэлдэг. Энэ онолд сэтгэл зүйн хүчин зүйлийг чухалчилдаг. Энэ онол хүний биологийн зөн билгийн үүргийг хэт

чухалчилж түүний нийгмийн мөн чанарыг үл тоомсорлодог нь хэтэрхий өрөөсгөл ойлголт юм [8].

“Тоглоомын онол”-ыг ХҮИИ зуунд Германы гүн ухаантан Шиллер, Английн философич Спенсер нар дэвшүүлсэн бөгөөд үүнийг “Шиллер-Спенсерийн онол” ч гэж нэрлэдэг. Энэхүү үзэл баримтлал нь гоо зүйн үйл ажиллагаа, хүний тоглоомын зөн совингоос үүдэлтэй бөгөөд хүн төрөлхтөн илүүдэл энергитэй болж түүнийгээ ямар ч практик ач холбогдолгүй үйл ажиллагаанд зарцуулдаг бөгөөд үүнийг чөлөөт “тоглоом” хэлбэрээр илэрхийлдэг [9].

Орчин үеийн боловсролын тогтолцоонд багш боловсролын шинэчлэлийн чухал субъект бөгөөд багшийн дүр төрх нь судалгааны нэг бие даасан асуудал болоод байна. Сүүлийн 30 жилийн хугацаанд судлаачид багшийн дүр төрхийн гол элементүүдийг задлан шинжилж, орчин үеийн багш нар хэрхэн төгс багшийн дүр төрхийг бий болгож чадах талаар олон судалгаа хийгдсэн. Багшийн дүр төрхийн онолын тухайд авч үзвэл зарим судлаачид багшийн дүр төрхийг, хэл яриа, зан байдал, харилцаа, гадаад төрх гэх мэт үзэгдлүүд гэж үздэг. Түүнчлэн ажил хэрэгч байдал, хэв маяг, ёс зүй зэрэг цогц чанаруудын гадаад илрэл [11], Ю Фан багшийнхаар дүр төрх нь үнэн хэрэгтээ боловсрол, заах арга зүй зэрэг бол багшийн мэргэжлийн үйл ажиллагаа юм гэж үзсэн. Тодорхой үзэл санаа, ёс суртахууны мэдрэмжийн ноёрхол дор бичиг үсэг, мэргэжлийн ур чадварт суурилсан соёлын, зан үйл [12], Ли Чуаннинг “Багшийн дүр төрх гэдэг нь сурган хүмүүжүүлэх үйл явцад сурагчдын сэтгэл хөдлөл болон бусад сэтгэл зүйн үйл ажиллагааг өдөөж чаддаг багшийн хандлага, дотоод оюун санааны ертөнцийг хэлнэ” [14] гэсэн байна.

ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

Судлаачдын багш мэргэжлийн онцлог үүргийг тодорхойлох асуудлаар хийгдсэн судалгаа түгээмэл байдаг ч багшийн дүр төрх түүний бүрдүүлэхэд гоо сайхны мэдрэмж мэдлэгт тулгуурлсан нарийвчилсан судалгаа дутагдалтай байна. Чех улсын нэрт сурган хүмүүжүүлэгч Я.Коменский “Агуу сургаалын онол”-доо гүн гүнзгий мэдлэгтэй, ёс суртахууны өндөр боловсролтой сургагч хүүхдийн сурган хүмүүжүүлэгч болж чадна гэж үзсэн [15]. Их Британийн сэтгэгч Ж Локк зөвлөгч /багш/ болохын урьдчилсан нөхцөл бол өөрийгөө зөв боловсронгуй болгох, зөв үг, үйлстэй байх явдал гэдгийг онцолсон байдаг [16]. Америкийн сурган хүмүүжүүлэгч Ж.Дьюи “Ардчилал ба боловсрол” бүтээлдээ мэргэшсэн багшийн хувьд сэтгэл зүйн мэдлэг туйлын чухал гэдгийг онцлон тэмдэглэсэн байна. Багш нь сурагчдын ур чадварын дагуу хичээл заахаас гадна сурагчдын идэвхийг сэргээж, чадавхийг нь хөгжүүлж чаддаг байх

ёстой [17]. Оросын нэрт сурган хүмүүжүүлэгч Ж.Калинин "Коммунист хүмүүжлийн тухай" бүтээлдээ багшийн дүр төрхийг өөрийн нийгмийн байдалд тохируулан тайлбарласан. Өөрөөр хэлбэл багш нар ерөнхийдөө өндөр боловсролтой, заах чадвар сайтай, "цэвэр" сэтгэлтэй хүмүүс байх ёстой. Сурган хүмүүжүүлэх ажлыг шударга, зөв хийж чаддаг хүнийг оюун ухааны инженер гэж хэлж болно гэж үзсэн [18].

Орчин үед Япон улс нийгмийн хөгжлийн шаардлагаар багшийн дүр төрхийг тасралтгүй шинэчлэгдэж багш нар нь "санаачлагч" мэргэжлийн ажилчдыг хүртэл удирдаж ирсэн [19] гэж үздэг. Хятад улс багшийн дүр төрхийг Циний өмнөх үеийнхээс тодорхойлж иржээ. Тухайлбал Күнзийн номлолд "халуун боловч догшин биш, хүчирхэг боловч догшин биш, хүндэтгэлтэй, амар амгалан" [20] байх нь багшийн дүр төрхийн дээд түвшний хураангуйлал дүрс юм гэсэн байдаг. Күнзийн "Багшлах ур чадвар дөрөв"-д

1. Нэр төрөөс үл айвал багш болно.
2. Хөгшин /туршлагатай/ итгэмтгий бол багш болно.
3. Энэ тухай яривал гомдохгүй бол багш болно.
4. Бага бус зүйлийг мэддэг бол багш болно" [21] энэ нь багшийн дүр юм гэжээ.

"Багш номлож, сургаж, эргэлзээг арилгадаг" хэмээн Хан Юйгийн сонгодог илэрхийллээр хэлж болно [22].

СУДАЛГААНЫ ХЭСЭГ

Хүүхэд, залуучуудыг сургах, төлөвшүүлэх үүрэг бүхий багшийн дүр төрх нийгмийн хөгжилд ихээхэн үүрэгтэй бөгөөд багш, сурагчдын харилцаа нь өсвөр насны хүүхдүүийн ирээдүйд чухлаар нөлөөлдөг билээ. Улаанбаатар хот дахь ерөнхий боловсролын Сэтгэмж цогцолбор сургууль, Лаборатори 93-р цогцолбор сургуулийн 6-9-р ангийн 120 сурагчдаас санамсаргүй түүврийн аргаар судалгаа авсан. Энэхүү судалгаа нь бага, дунд, ахлах ангийн сурагчдын хүмүүжилд багшийн гоо зүй байдал, багшийн биеэ авч явах соёл тэдний сэтгэлд зүйд хэрхэн эерэг нөлөө үзүүлдэгийг судлах, дунд сургуулийн сурагчдын багшийн дүр төрхийг судлах зорилготой. Мөн сурагчдаас багш нарын гоо зүйн байдал /гадаад имиж/ 20-30 минутын ярилцлага хийсэн.

Судалгааны онолын ач холбогдол: Гоо сайхныг эрхэмлэх нь хувь хүний гоо зүйн сэтгэл зүйн бүтцийн чухал хэсэг юм. Өсвөр насныханд багшийн заах арга барилаас гадна сэтгэл зүй /дотоод дүр/, биеэ авч явах байдал /гадаад дүр/ ихээхэн чухал нөлөөлдөг. Багш нарын өмнө тулгардаг чухал асуудлын нэг болох дээрх ойлголт онолын ач холбогдолтой гэж үзэж байна. Иймд багшийн дүр төрх нь сурагчдын сэтгэл

зүйн хөгжил, гоо зүйн чадварыг төлөвшүүлэхэд хэрхэн нөлөөлж, сурагчдад өөрийн гэсэн дүр төрхийг төлөвшүүлэх замаар яаж зөв хүмүүжүүлж, чиглүүлэх, ингэснээр сурагчдад ертөнцийг үзэх үзэл, амьдралыг үнэлэх үнэлэмжийг зөв төлөвшүүлэх, сэтгэл зүйн сайн чанарыг бүрдүүлнэ.

Судалгааны практик ач холбогдол: Өнөөгийн соёлын өвөрмөц орчин нь өвөрмөц гоо зүйн ухамсрыг төлөвшүүлж байдаг бөгөөд ахлах ангийн сурагчдын багшийн гадаад дүр төрхийг гоо зүйн талаас ажиглаж үлгэр дууриал авдаг болох нь олонтоо ажиглагдсан.

Судалгааны агуулга

Багшийн дүр төрх нь гоо зүйн үзэмжийн хувьд тодорхой хэмжээгээр янз бүрийн нөлөөллийн үр дүнд бий болдог. Сэтгэл судлалын үүднээс сургуулийн сурагчдын багшийн дүр төрхийг сонгох гоо зүйн сонирхлыг судлах нь өнөөгийн багш нарын гоо зүйн сонирхлыг судлах зорилготой юм. Шинж чанарууд ба тэдгээрийн цаана байгаа сэтгэл зүйн утга учир, сурагчдын гоо зүйн сонирхол, гоо зүйн сонголтын талаар судалгааны явцын үр дүнгээр харуулах болно.

1. Бага ахлах ангийн сурагчдын багшийн дүр төрхийг гоо зүйн хувьд илүүд үздэг онцлог шинж чанарыг ярилцлагын тусламжтайгаар ойлгох
2. Ярилцлагын үр дүнд үндэслэн "ЕБС-ийн сурагчдын багшийн дүр төрхийг тодорхойлох гоо зүйн сонголтын асуулга"-ыг боловсруулах
3. Санал асуулгын үр дүнгээс үзэхэд бага ахлах ангийн сурагчдын багшийн дүр төрх дэх гоо зүйн үзэмжийг шинжлэх зэргийг судлахыг зорилоо.

Орчин үеийн багшийн дүр төрхийг сонгох нь энэ судалгааны нэг шинэлэг тал юм. Багш нарын тухай судалгаа ихэвчлэн утга зохиол, социологи, урлаг зэрэгт дүрслэгдэх нь түгээмэл байдаг бөгөөд багшийн сэтгэл зүйн талаарх судалгаа чухал болж байна. Эртнээс уламжлагдан ирсэн соёл иргэншил, ахуй, гэр бүлийн орчинд багшийн уламжлалт уламжлалт соёлын элементүүд агуулагдсаар ирсэн буй. Багшийн дүр төрхийг бага дунд сургуулийн сурагчд гоо зүйн талаас харах нь энгийн ойлголт, харин багшийн дүр төрхийн мөн чанарыг тэдэнд тайлбарлах нь хүмүүжлийн ач холбогдолтой.

Дотоод болон гадаадын уран зохиолын хэмжээнд багшийн дүр төрхийг судлах нь ихэвчлэн үзэл баримтлалын түвшинд төвлөрдөг боловч эмпирик судалгааны дэмжлэг дутмаг хэвээр байна. Энэхүү судалгаа нь тухайн сэдвийн хил хязгаарыг ойлгож, багш нарын гоо зүйн үзэмжийн хэмжилт, туршилтын аргаар судалсан бөгөөд дотоод, гадаадад тодорхой хэмжээний ирээдүйг хардаг тул сэдвийн сонголтын үзэл баримтлалд шинэлэг зүйл бий. Энэхүү судалгаа нь дунд ангийн сурагчдаас багшийн

дотоод болон гадаад гоо зүйн талаар ярилцлага, асуулгын аргаар судалгаа авсан. Нэмж дурдахад багшийн хувийн шинж чанарын дотоод болон гадаад гоо зүйн давуу талыг тодорхойлж, улмаар багшийн нөлөөллийн талаар дүгнэлт хийсэн. Сүүлийн жилүүдэд нийтийн гоо сайхны асуудлыг судлахад уран зохиол, гоо зүй, урлагийн салбарууд судлахдахуунаа чиглүүлэх болжээ. Мөн сурагчдын гоо зүйн талаарх ахлах ангийн сурагчдын мэдлэг, ойлголт, танин мэдэхүйн түвшин хөгжил [24] хурдацтай хөгжиж байна. Сурагчдын ерөнхий сэтгэлгээ, төсөөлөл өөрчлөгдөж, гоо зүйн сэтгэлгээний н бүтэц аажмаар сайжирч, гоо зүйн мэдрэмж, гоо зүйн үнэлгээ, гоо зүйн үзэл санаа зэрэг нь гоо зүйн ухамсар болон бүрэлдэн бий болсон [25]. Гоо сайхныг эрхэмлэх тухай судалгаа нь гоо зүйн сэтгэл судлалын чиглэлээр, голдуу уран зураг, өнгө үзэмжийн чиглэлээр харьцангуй төвлөрч, сайн үр дүнд хүрсэн. Гадаадын ихэнх судалгаанд урлаг, гоо зүй зэрэг бусад салбаруудын судалгааны объект, холбогдох онолыг гоо зүйн таашаалын судалгаанд нэвтрүүлж, улмаар түүнийг шалгахын тулд сэтгэл зүйн судалгааны аргыг ашигласан байдаг.

Гоо зүйн нь бидний амьдралд бүрэн нөлөөлж хүмүүс, нийгэм, байгаль хоёрын харилцааны онцгой хэлбэр гэж тодорхойлж болно. Энэхүү харилцаа холбоогоор дамжуулан хүмүүс бид ертөнцийг илүү сайн, бүрэн дүүрэн ойлгож чадна [26]. Субъектив түвшинд, объектив түвшинд, сэтгэл хөдлөл, оюуны хувьд хамаагүй, гоо зүй нь хүмүүст нийгмийг бүрэн дүүрэн ойлгож, бидний ертөнцийг илүү сайн ойлгох боломжийг олгодог. "Гоо зүй" гэдэг үгийг хувааж, задлан шинжилж болно. Мөн тэдгээрийн өөр өөр өсөлтийн орчин, нийгмийн орчин, өөр субъект бүр өөр амьдралын туршлагатай байх ба хичээл бүрийн сонирхол, хобби нь бас өөр байдаг. Дээрх зүйл нь субъект бүрийн гоо зүйн ухамсрыг илүүд үздэг ялгаатай байдлыг бий болгодог [27].

Хүснэгт 1. Ярилцлагын асуултууд болон хариултын давтамж өндөртэй тулхуур үгс

№	Асуулт	Хамгийн их давхардсан хариулт
1	Ямар багш "сайн" багш вэ?	Хичээлээ заахдаа сайн, сурагчдыг ойлгодог, сонсох чадвартай, бүх багшид дуртай, эрэгтэй багш, даруу, гэрийн даалгавар багатай, цаг барьдаг, сурагчдыг урамшуулдаг
2	Багшийн ямар зан чанар таалагддаг вэ?	Дөлгөөн зантай, шударга, боломжийн, залуу, эрч хүчтэй, инээмсэглэлтэй, сайхан хоолойтой, сургачдад тустай, царайлаг
3	Таны бодлоор багшид ямар чанарууд байх ёстой вэ?	Найз шиг, нухацтай, сурагчдыг бүрэн дэмждэг, үнэнч шударга, худлаа ярихгүй, өөрийгөө хөгжүүлэх тал дээр анхаарч, өөртөө итгэлтэй, ажиглах чадвар сайтай, бүх чадвартай, эелдэг найрсаг, сурагчдыг магтаж урамшуулах, өөрийн туршлагаасаа хуваалцахдаа сайн
4	Багшийн сургалтын явуулж буй ямар аргыг илүүд үздэг вэ?	Багшлах практик арга зүйтэй хичээл заах, хичээлээс гадуурх сургалт ба мэдлэг олгох, нөхцөл байдлыг зааж тайлбарлах, гэрийн даалгавар, сургалт, өөртөө итгэх итгэлийг бий болгох, сурагчдын суудлыг солих, сургуулиас гадна үйл ажиллагаа явуулах зэрэг

5	Та багшийн ямар хувцас өмсөхөд дуртай вэ?	Албаны хувцас, үндэсний хувцас, загварлаг, тод өнгө, урт үстэй цэвэрхэн, ухаалаг хувцас, эрэгтэй костюм, өөртөө тохирсон хувцас, сурагчдын шүтээнтэй хувцас, биеийн галбирыг харуулсан хувцас
---	---	---

Ярилцлагын үр дүнгээс үзэхэд энэхүү судалгаа нь гол агуулгын төлөөлөх байдлыг харгалзан сурагчдын хариулсан хамгийн их давтамжтай түлхүүр үгсийг сонгон авч нэгтгэсэн болно. Иймд энэ судалгаанд ЕБС-ийн сурагчидтай хийсэн ярилцлагын үр дүнд тулгуурлан "Ерөний боловсролын сургуулийн сурагчдын багшийн дүр төрхийг тодорхойлох гоо зүйн сонголтын асуулга" нэртэй судалгааны хамгийн их давхардсан ижил хариулт


1. Хичээл сайн заадаг багш нарт дуртай;
2. Дөлгөөн, найрсаг багшид дуртай;
3. Хичээлээс гадуурх сургалт явуулдаг багшид дуртай
4. Мэдлэгийг өргөжүүлдэг багш нарт дуртай;
5. Цэвэрхэн хувцасласан багшид дуртай гэсэн хариултууд байсан.

Эдгээр асуулгад урвуу оноо байхгүй бөгөөд нэг хэмжээст бүтэцтэй 1 (бүрэн санал нийлж байна)-аас 5 (бүрэн санал нийлэхгүй байна) хүртэлх 5 онооны системийг ашигласан.

Сурагчдын ярилцлагын судалгааны үр дүн

ЕБСургуулийн сурагчидтай хийсэн чанарын ярилцлагад “Та ямар багшид дуртай вэ?” гэсэн асуултад сурагчдын хариултаас сайн багш, ойлгох, сонсох, бүх багшид дуртай, эрэгтэй багш, даруухан багш, гэрийн даалгавар бага өгдөг багш, цаг барьдаг, хэзээ ч хоцродоггүй багш, сурагчдыг урамшуулдаг багш гэж олонх нь хариулсан найман өндөр давтамжтай хариултыг сонгосон. Бага ахлах ангийн сурагчид ямар төрлийн багшид дуртайг нь асуухад 29.2% нь сайн багшид, 17.4% нь сурагчдын санаа бодлыг ойлгодог, сонсдог багшид дуртай гэж хариулсан бол 13.5% нь бүх багш нарт, 11.8% нь зөвхөн эрэгтэй багшид дуртай, 10.3% нь даруухан багшид, 8.5% нь гэрийн даалгавар багатай багшид, 7.9% нь цаг барьдаг, хэзээ ч хоцордоггүй багш нарт дуртай, 1.45 хувь нь сурагчдыг урамшуулдаг багш нарт дуртай гэж хариулжээ.


Зураг 1. Ямар багш “сайн” багш вэ?



Багшийн зан чанарын талаар "Багшийн ямар зан чанар таалагддаг вэ?" гэсэн сурагчдын хариултаас 8 өндөр давтамжтай хариултыг сонгосон бөгөөд үүнд: зөөлөн ааштай, найрсаг зантай багш, шударга, боломжийн багш нар, залуу эрч хүчтэй багш нар, нүүрэндээ инээмсэглэлтэй багш нар, сайхан хоолойтой багш нар, сурагчдад тусладаг багш нар гэж дийлэнх нь хариулсан.

Тэд Багшийн ямар зан чанар таалагддаг вэ? гэсэн асуултад сурагчдын 28.2% нь дөлгөөн зантай найрсаг багшид дуртай, 18.4% нь шударга багш, 12.5% нь боломжийн, 12.8 хувь нь залуу, эрч хүчтэй багш, 8.3% нь инээмсэглэдэг багш, 10.5% нь сайхан хоолойтой багшид, 6.4% нь сурагчдад тусладаг багш, 2.9% нь сайхан бие галбиртай багшид дуртай гэж хариулжээ.

Зураг 2. Багшийн ямар зан чанарт дуртай вэ?



Мөн багшийн зан ааш нь дунд ангийн сурагчдад эелдэг, даруу, үнэнч шударга, дөлгөөн зантай, найрсаг зан чанартай, сайн харилцаж чаддаг, дасан зохицдог, ойлгодог, сурагчдыг өөрийн гэсэн байр сууринд тавьж чаддаг багшийг илүүд үздэг нь харагдаж байсан.


Зарим тохиолдолд багш нарын зан ааш сурагчдын сэтгэлийг хөдөлгөдөг учраас ийм багш нар таалагддаг гэж хариулсан байсан.

Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчидтай хийсэн ярилцлагад: "Сайн багш ямар шинж чанартай байх ёстой боддог вэ?" гэсэн асуултад сурагчдын хариултаас өндөр давтамжтай хариултыг сонгосон. Үүнд сурагчидтайгаа найз нөхөд шиг харилцах, бүрэн дэмжиж чаддаг, үнэнч байж, худал хэлэхгүй байх, өөрийгөө хөгжүүлэх, өөртөө итгэх итгэлд анхаарлаа төвлөрүүлэх, ажиглах чадвар өндөр, бүх чадварыг эзэмшсэн, эелдэг, найрсаг, магтаал нь сурагчдад урам зориг өгдөг, өөрийнхөө туршлагаас хуваалцахдаа сайн зэрэг хариултуудыг өгчээ.

Судалгааны үр дүнгээс харахад 26% нь сайн багш нар нухацтай байх ёстой гэж боддог, 19% нь сайн багш сурагчидтай найз шиг харьцах ёстой, 13% нь сайн багш нар сурагчдыг дэмжихийн тулд бүх хүчээ


дайчлан ажиллах чадвартай байх, 13% нь сайн багш нар шударга байх ёстой, 9% нь сайн багш эелдэг, найрсаг байх ёстой, 2% нь сайн багш нар сурагчдыг магтаж, урамшуулдаг байх, 1% нь сайн багш нар туршлагаа хуваалцдаг байх ёстой гэж үзсэн байна.

Зураг 3. Сайн багш ямар шинж чанартай байх ёстой гэж боддог вэ?



Багшийн заах арга зүйг илүүд үздэг байдалд хийсэн ярилцлагын талаарх асуулгын дүн шинжилгээнд "Та ямар багшийн арга барилд дуртай вэ?" асуултад сурагчид бүлгийн сургалт, практик хичээл, хичээлээс гадуурх сургалт, мэдлэг олгох ажлыг өргөжүүлэх, маш олон гэрийн даалгавар, сурагчдын өөртөө итгэх итгэлийг хөгжүүлэх, сурагчдын хооронд суудал солих, сургуулиас гадуур үйл ажиллагаа явуулах гэх мэт хариултыг өгсөн байсан. Мөн багш нар ямар хувцас өмсөхийг илүүд үздэг тухай сурагчдын ярилцлагын дүн шинжилгээнд "Багш ямар хувцас өмсвөл дуртай вэ?" гэсэн асуултын олон давтагдсан хариултаас сонгосон. Үүнээс үзэхэд албаны хувцас, үндэсний хувцас, загварлаг, өнгөлөг хувцас, урт үстэй цэвэрхэн хувцас, эрэгтэй костюм, сайхан мэдрэмж төрүүлэх хувцас, шүтээнтэй хувцас, таны дүр төрхийг харуулсан хувцас зэргээр хариулсан байсан.

Зураг 4. Багш ямар хувцас өмссөн байвал дуртай вэ?



Эдгээр хариултаас харахад хамгийн их саналтай 20,1%-ийн “шүтээнтэй хувцас” гэсэн хариулт нь сурагчид өөрсдийн шүтэн биширдэг жүжигчин, дуучин, хамтлаг, тамирчин, бусад нэр алдартай хүмүүсийн зурагтай хувцас багш өмссөн байхад илүү дуртай байдаг нь судалгаанаас харагдаж байна.

ДҮГНЭЛТ

Энэхүү судалгаа нь ЕБСургуулийн сурагчдын дунд гоо зүйн үзэмж, гоо зүйн талаарх ойлголт, багш нарын дүр төрх тэдэнд хэрхэн нөлөөлж байгааг судалсан болно. Ярилцлагын аргаар бага ахлах ангийн сурагчдын багшийн дүр төрхийг сонгох гоо зүйн шинж чанар, өнөөгийн нөхцөл байдлыг ойлгож, "сурагчдын багшийн дүр төрхийг сонгох гоо зүйн талаарх санал асуулга"-ыг эмхэтгэн, сурагчдын багшийн дүр төрхийг сонгох гоо зүйн сонирхлыг судлахад дүн шинжилгээ хийж асуулгын үр дүнгийн дагуу багшийн дүр төрхийг судалгааг боловсруулсан болно.

Судалгаанаас үзэхэд: Бага, ахлах, ангийн сурагчдын 29.2% нь сайн багшид дуртай, сурагчдын 28% нь зөөлөн ааштай, найрсаг хандлагатай багшид дуртай, сурагчдын 26% нь сайн багш нухацтай байх ёстой, 25% нь багшлах арга зүй сайн сайн байх ёстой гэж үзжээ. Сурагчдын 17% нь багш нарыг сайхан хувцаслахыг илүүд үздэг байна.

Сургуулийн сурагчидтай хийсэн ярилцлагын үр дүнд тулгуурлан таван сэдвийг багтаасан асуулга боловсруулсан нь дунд сургуулийн сурагчдын багшийн дүр төрх гоо зүйн сонирхлыг судлах нөхцөлийг бүрдүүлсэн. Санал асуулгын үр дүнд дараах дүгнэлтэд хүрлээ.

1. Дунд сургуулийн сурагчдын багшийн дүр төрхийг тодорхойлох гоо зүйн судалгааны хэрэгсэл болгон ашиглах боломжтой;
2. Бага, ахлах ангийн сурагчид багшийн ямар зан чанарыг таашаадаг нь хүйсийн хувьд ялгаа тийм чухал биш;
3. Багшийн зан чанарын тухайд сурагчдын үзэж байгаагаар хүйсийн ялгаа нь тийм ч чухал биш;
4. Бага, ахлах ангийн сурагчдын багшийн заах арга барилыг илүүд үзэхэд ангийн ялгаа байхгүй, харин хүйсийн ялгаа их байна;
5. Багш нарын өмсөх дуртай хувцас нь бага дунд сургуулийн сурагчдын анги, хүйсийн хувьд мэдэгдэхүйц ялгаа байхгүй;
6. Бага, ахлах ангийн сурагчдын багшийн дүр төрхийг сонгоход нас нь ихээхэн нөлөө үзүүлдэг боловч хүйс нь сурагчдын багшийн дүр төрхийг гоо зүйн хувьд илүүд үздэггүй.

Бага, дунд ангийн сурагчдын багшийн дүр төрхийн хэлбэр, төлөвшлийг судлах зорилго нь сурагчдад багшийн дүр төрхийн ач холбогдлыг ойлгуулж, багшийн дүр төрх, зөв санааг ойлгоход анхаарал

хандуулах, багшийн бүтээлч сэтгэлгээ, үнэ цэнийн эрэл хайгуулыг хөгжүүлэхэд оршино. Багшийн дүрд цаашид сурагчдад урлагийн заах арга барилыг судлах талаар санал өгөх.

Үүнд:

1. Юуны өмнө би өөрийн багшийн дүр төрхийг хэрхэн бүрдүүлэх вэ? Сургуулийн дэмжлэг, сургалтаас гадна багшийн өөрийнх нь хандлага, сэтгэл хамгийн чухал.
2. Багшид "хичээл заахдаа баясах" сэтгэлтэй, онолын болон мэргэжлийн бат бөх суурь байх ёстой. Энэ нь багшийн дүр төрхийг бүрдүүлэх үндсэн нөхцөл юм.
3. Багш өөрийн зан чанарын онцлогийг зөв ойлгож, зөв байр сууриа олох хэрэгтэй.
4. Багш нар өөрийн багшийн дүр төрхийг байнга эргэцүүлэн бодож байх хэрэгтэй.

Тиймээс өөрийн гэсэн багшлах дүр төрхийг шалгана, үүний үндсэн дээр багш нар өөрийн өвөрмөц байдлыг бүрэн дүүрэн харуулж, хувийн шинж чанартай багшийн дүр төрхийг бүрдүүлэхийг хичээх хэрэгтэй. Эцэст нь багш нар багшийн дүр төрхийг бий болгоход ухамсар, өөртөө итгэх итгэлийг давж, цаг үеийн тэргүүн эгнээнд алхвал багшийн дүр төрх өсөх болно. Багш сурагчиддаа сайн үлгэр дуурайл үзүүлж, тэднийг хөгжүүлэхэд туслах нь чухал юм.

НОМ ЗҮЙ

- [1]. Наранцацрал Д. Гоо зүйн үндэс. УБ., 2013 он. 22,62 хх
- [2]. Радугин А. Гоо зүй. УБ., 2013 он
- [3] Masuda T, Gonzalez R, Kwan L, et al. Culture and aesthetic preference: comparing the attention to the context of East Asians and Americans. *Pers Soc Psychol Bull*, 2008, 34(9):1260-1275
- [4]. Mcmanus I, Furnham A. Aesthetic activities and aesthetic attitudes [J]. *Journal of Traumatic Surgery*, 2006
- [5]. 彭文祥. 试论“真”是古希腊美学的逻辑起点[J]. *广西社会科学*, 1995,6:101-105.
- [6]. 周宁. 西方美学中与艺术起源相关的原始审美概念[J]. *大观(论坛)*, 2018,11:169-170.
- [7]. 柯华. 柏拉图的摹仿说—对艺术的摹仿[J]. *文学教育*, 2009,14:27-28.
- [8]. 孟允美. 从劳动到艺术[J]. *河北大学学报(哲学社会科学版)*, 1990,4:51-56.
- [9]. 李梦. 原始思维的具体性与中国美术[J]. *湖北美术学院学报*, 2000,3:7-9.
- [10]. 赵琳. 埃伦·迪萨纳亚克审美生物本能论研究[D]. *广西师范大学*, 2014.
- [11]. 马振涛. 论赫伯特·斯宾塞的艺术游戏说[J]. *作家*, 2009,4:171-172.
- [12]. 薛利东. 浅谈内蒙古阴山岩画中巫术与审美发生之间的关系[J]. *大众文艺*, 2012, 22 (304):184-194.
- [13]. 冯铁山. 高师课程改革与未来中小学教师形象塑造[J]. *扬州大学学报(高教研究版)*, 2004,3:52-55.
- [14]. 余芳. 论教师形象在教育育人中的作用[J]. *胜利油田师范专科学校学报*, 2003,17(3):42-43.
- [15]. 李径宁. 略谈教师形象[J]. *宝鸡文理学院学报(哲学社会科学版)*, 1995,2:119-121.

- [16]. 夸美纽斯. 大教学论. 新1版[M]. 北京:人民教育出版社,1979.
- [17]. 约翰·洛克. 教育漫话. 第2版[M]. 上海:上海人民出版社, 2011.
- [18]. 约翰·杜威. 民主主义与教育[M]. 北京:中国轻工业出版社, 2014.
- [19]. 加里宁. 论共产主义教育和教学[M]. 北京:人民教育出版社,1957.
- [20]. 余芳. 论教师形象在教书育人中的作用[J]. 中国石油大学胜利学院学报, 2003, 17(3):42-43.
- [21]. 李成学,罗茂全. 教师的素质与形象[M]. 四川:四川教育出版社, 2010.
- [22]. 向丽. 走向跨学科的美学研究——近年来审美人类学研究综述[J]. 民族艺术,2006,3:81-89.
- [23]. 徐桂英. 根据青少年身心发展的特点开展素质教育[J]. 课外阅读旬刊, 2013,6: 66.
- [24]. Masuda T, Gonzalez R, Kwan L, et al. Culture and aesthetic preference: Comparing the attention to context of East Asians and Americans [J]. *Personality and Social Psychology Bulletin*, 2008, 34(9): 1260-1275.
- [25]. 觉传达,王璐. 视觉化时代下基于提升青年人审美能力的艺术方法论研究[J]. 青年科学:教师版, 2012,11:49-50.
- [26]. Kociuba D, Kociuba W. Potencjał turystyczny Lublina jako czynnik rozwoju miasta na przestrzeni wiekyw [J]. *Annales Universitatis Mariae Curie Skłodowska Sectio B*, 2009, 64(1):212-227.
- [27]. Kociuba D, Kociuba W. Potencjał turystyczny Lublina jako czynnik rozwoju miasta na przestrzeni wiekyw[J]. *Annales Universitatis Mariae Curie Skłodowska Section B*, 2009,